



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Хажуу шинэ ус

Байгууллагын Баримт нягтлан шалгах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Монгол Улсын Хууль зүйн, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн А/222 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 2.8, 2.9, 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Баримт нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга Н.Ганбат (Санхүү албаны даргын түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд: Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)
Д.Алтансаргай (Татварын Улсын байцаагч)
Г.Булган (Нийгмийн даатгалын Улсын байцаагч)

Комиссын нарийн бичгийн дарга

Э.Лайжинханд (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

2.Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын дүрмийг хавсралтаар баталсугай.

3.Засаг даргын Тамгын газрын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх арга зүйн баримт бичгийг боловсруулах, хөтлөгдөж дууссан хэргийг архивд шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах ажлыг зааврын дагуу зохион байгуулахыг комиссын дарга (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ӨЛЗИЙТОГТОХ

482205001

Засаг даргын Тамгын газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 02 өдрийн 1/01
дүгээр тушаалын хавсралт

**БАРИМТ НЯГТЛАН ШАЛГАХ
КОМИССЫН ДҮРЭМ**

Нэг Нийтлэг үндэслэл

1.1 Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах байгууллагын Баримт нягтлан шалгах комисс (БНШК)-ын үйл ажиллагаанд үүссэн харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2 Баримт нягтлан шалгах ажлыг Засаг даргын Тамгын газрын даргын Тушаалаар томилогдсон БНШК удирдан зохион байгуулна.

Хоёр. Зорилт, чиг үүрэг, эрх

2.1 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөх хэргийг архивд шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах ажлыг зохион байгуулах

2.2 Байнга, түр хадгалах болон устгах хэргийг ялгах, сонгох ажлыг жил бүр зохион байгуулах

2.3 Байгууллагын баримт бичгийг хадгалах хугацааны жагсаалтаар тогтоосон зарим нэр төрлийн баримтын хадгалах хугацаанд өөрчлөлт оруулах жагсаалтад ороогүй баримтын хадгалах хугацааны талаар санал боловсруулж БНШК-ын хурлаар оруулах

2.4 Архив албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх арга зүйн баримт боловсруулахад оролцох, хэлэлцэх

2.5 Архивын ажилд зайлшгүй шаардлагатай бүртгэл, жагсаалт зэргийг зохион байгуулалтын нэгж ажилтнаас гаргуулан авах

2.6 Архивын ажлыг сайжруулах боловсронгуй болгох асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал дүгнэлт гаргах

Гурав. БНШК-ын ажлын зохион байгуулалт

3.1 Засаг даргын Тамгын газрын хэмжээнд хөтлөгдөж байгаа албан хэрэг боловсруулах ажиллагааны үндэслэл баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллахад хяналт тавьж зөвлөмж, зааварчилгаа өгч байх

3.2 БНШК нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх, комиссын даргаар Санхүү албаны дарга, комиссын гишүүдэд Засаг даргын Тамгын газрын ажилтан, нарийн бичгийн даргаар архив бичиг хэргийн эрхлэгч ажиллана.

3.3 БНШК нь жилд 2-оос доошгүй удаа хуралдаж асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. БНШК-ын хурлын тэмдэглэлд оны эхнээс дугаар өгч комиссын дарга гарын үсэг зурж байгууллагын тэмдгээр баталгаажуулна.

3.4 Хурлаар хэлэлцэх асуудлыг нарийн бичгийн дарга гишүүдэд урьдчилан танилцуулж, хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3.5 Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах явцад байнга хадгалах хэрэг, түр хадгалах хэргийг тус тусад нь ангилан төрөлжүүлэхийн зэрэгцээ хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулсан байдал, хэргийн хадгалах хугацааг зөв тогтоосон эсэхийг шалгана.

Дөрөв Бусад

4.1 БНШК нь тогтмол хариуцлагатай ажиллана.

4.2 Энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн албан тушаалтанд Дотоод журам, Ёс зүйн дүрэм болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

4.3 Шаардлагатай тохиолдолд хурлаар хэлэлцэн энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.